| 210104 | Урамшуулал                                     | 244,740,000.00   | 167,863,517.00              | 76,876,483.00   | 68.6             |
| 210105 | Гэрээт ажлын хөлс                              | 0.00             | 870,509.00                  | -870,509.00     | -                |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 119,377,300.00   | 96,523,279.00               | 22,854,021.00   | 80.9             |
| 210201 | Тэтгэврийн даатгал                             | 81,176,600.00    | 64,448,022.37               | 16,728,577.63   | 79.4             |
| 210202 | Тэтгэмжийн даатгал                             | 9,550,200.00     | 8,961,022.00                | 589,178.00      | 93.8             |

|             |  |                         |                       |                       |              |
|-------------|--|-------------------------|-----------------------|-----------------------|--------------|
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 7,640,100.00            | 6,182,078.38          | 1,458,021.62          | 80.9         |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 1,910,000.00            | 1,539,286.62          | 370,713.38            | 80.6         |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 19,100,400.00           | 15,392,869.63         | 3,707,530.37          | 80.6         |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>14,046,700.00</b>    | <b>12,842,736.57</b>  | <b>1,203,963.43</b>   | <b>91.4</b>  |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 2,400,000.00            | 2,093,106.57          | 306,893.43            | 87.2         |
| 210302      | Түлш, халаалт  | 10,646,700.00           | 10,069,170.00         | 577,530.00            | 94.6         |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 1,000,000.00            | 680,460.00            | 319,540.00            | 68.0         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>19,137,000.00</b>    | <b>16,537,348.64</b>  | <b>2,599,651.36</b>   | <b>86.4</b>  |
| 210401      | Бичиг хэрэг  | 4,040,000.00            | 4,045,560.00          | -5,560.00             | 100.1        |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 7,101,000.00            | 5,359,220.00          | 1,741,780.00          | 75.5         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 2,900,000.00            | 2,179,683.64          | 720,316.36            | 75.2         |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 96,000.00               | 82,560.00             | 13,440.00             | 86.0         |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 5,000,000.00            | 4,870,325.00          | 129,675.00            | 97.4         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>6,133,000.00</b>     | <b>5,863,550.00</b>   | <b>269,450.00</b>     | <b>95.6</b>  |
| 210604      | Урсгал засвар  | 6,133,000.00            | 5,863,550.00          | 269,450.00            | 95.6         |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>6,422,000.00</b>     | <b>5,096,000.00</b>   | <b>1,326,000.00</b>   | <b>79.4</b>  |
| 210702      | Дотоод албан томилолт  | 6,422,000.00            | 5,096,000.00          | 1,326,000.00          | 79.4         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>47,801,000.00</b>    | <b>47,782,926.00</b>  | <b>18,074.00</b>      | <b>100.0</b> |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 46,525,200.00           | 46,515,600.00         | 9,600.00              | 100.0        |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 720,000.00              | 720,000.00            | 0.00                  | 100.0        |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 369,200.00              | 369,200.00            | 0.00                  | 100.0        |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 71,900.00               | 63,426.00             | 8,474.00              | 88.2         |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 22,000.00               | 22,000.00             | 0.00                  | 100.0        |
| 210807      | Газрын төлбөр  | 92,700.00               | 92,700.00             | 0.00                  | 100.0        |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>7,055,000.00</b>     | <b>6,505,800.00</b>   | <b>549,200.00</b>     | <b>92.2</b>  |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 7,000,000.00            | 6,505,800.00          | 494,200.00            | 92.9         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>2,750,000.00</b>     | <b>2,750,000.00</b>   | <b>0.00</b>           | <b>100.0</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>2,750,000.00</b>     | <b>2,750,000.00</b>   | <b>0.00</b>           | <b>100.0</b> |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 2,750,000.00            | 2,750,000.00          | 0.00                  | 100.0        |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>1,177,739,500.00</b> | <b>980,561,951.21</b> | <b>197,177,548.79</b> | <b>83.3</b>  |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>1,177,739,500.00</b> | <b>980,561,951.21</b> | <b>197,177,548.79</b> | <b>83.3</b>  |
| 310001      | Улсын төсвөөс санхүүжих  | 1,177,739,500.00        | 980,561,951.21        | 197,177,548.79        | 83.3         |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код    | Үзүүлэлт  | /Төгрөг/<br>гүйцэтгэл |
|--------|---|-----------------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН   | 19,662,375.00         |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ   | 19,662,375.00         |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ   | 19,662,375.00         |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил   | 17,211,000.00         |
| 210101 | Үндсэн цалин  |                       |
| 210102 | Нэмэгдэл  | 17,211,000.00         |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл  | 2,151,375.00          |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 300,000.00            |
| 1311   | Нэмэлт санхүүжилтийн орлого   | 19,662,375.00         |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,662,375.00         |
| III    | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)  | 0.00                  |
| 9      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.00                  |
| 10     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   | 0.00                  |

## 2.3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Татварын хэлтэс нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Татварын Ерөнхий Газрын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах
- Татварын хууль тогтоомжид хяналт тавих
- Улс орон нутгийн татварын орлого бүрдүүлэх
- Төрийн захиргааны удирдлагаар хангах хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийх
- Мэдээллийн технологид суурилсан "Цахим татварын алба" болох зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант онд Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай ЗГ-ын 240-2 дугаар хавсралт, 241-ийн 6, 10 дугаар хавсралт, ЭХЗХ-ны 2022 оны 504, 514 дугаар тогтоолоор 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс цахилгаан эрчим хүчний тарифт өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзсэн.

Татварын хэлтэс нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан байхгүй байна. Ерөнхий газрын дотоод аудитын нэгжээс дотоод аудитыг хэрэгжүүлдэг. Бусад эрх бүхий байгууллагаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн "Татварын хэлтэс"-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн "Татварын хэлтэс" -ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн Дундговь аймгийн "Татварын хэлтэс"-ийн бодлого, чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,349.9 мянган төгрөгөөр буюу 17.1-иар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                            | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт  |
|-------------------------------------|----------------|-----------------|-----------|
| Б                                   | 1              | 2               | 3=2-1     |
| Мөнгөн хөрөнгө                      | 16,259.5       | 28,709.5        | 12,450.0  |
| Авлага                              | 0,0            | 3,710.5         | 3,710.5   |
| Бараа материал                      | 78,079.9       | 86,042.6        | 7,962.7   |
| Үндсэн хөрөнгө                      | 252,920.7      | 169,447.6       | -83,473.1 |
| Нийт хөрөнгийн дүн                  | 347,260.1      | 287,910.2       | -59,349.9 |
| Нийт өр төлбөр                      | 0.0            | 244.0           | 244.0     |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн            | 347,260.1      | 287,666.2       | -59,593.9 |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн | 347,260.1      | 287,910.2       | -59,349.9 |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 28,709.5 мянган төгрөг нь ахмадын сангийн дансны үлдэгдэл байна.

Бараа материал дансны үлдэгдэл 86,042.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,962.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь төсвийн хөрөнгөөр 25,852.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан ба ТЕГ-аас 772.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 18,662.4 мянган төгрөгийн зарцуулалтай тайлагнасан байна

Тайлант онд үндсэн хөрөнгө 83,473.1 мянган төгрөгөөр буурсан нь ТЕГ-аас 8,437.8 мянган төгрөгийн проектор дэлгэц үнэ төлбөргүй авч бүртгэсэн, зарлагын гүйлгээ байхгүй боловч элэгдлийн зардлыг 91,910.9 мянган төгрөгөөр тооцсонтой холбоотой байна. Акталж устгасан үндсэн хөрөнгө байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 287,666.2 мянган төгрөг болж 59,593.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 661,990.0 мянган төгрөг, нийт зарлагыг 660,890.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 516,849.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,177,739.5 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд энэ нь ЗГ-ын 2023 оны 241 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчдын цалин хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр 1,177,739.5 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,177,739.5 мянган төгрөг, санхүүжилт хүлээн авч, 980,561.9 мянган төгрөгийн төсөв зарцуулж, төсвийн гүйцэтгэл 83.3 хувьтай бөгөөд 197,177.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь сумдад орон тоогоор ажиллах татварын байцаагчид дутуу ажилласантай холбоотой.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр харуулбал:

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү     | Биелэлт |
|-----------------------|-----------------------|-----------|-----------|---------|
| 80101 <sup>1</sup>    | 1,131,181.3           | 934,013.3 | 197,168.0 | 82.6    |
| 80205 <sup>2</sup>    | 1,500.0               | 1,490.4   | 9.6       | 99.4    |
| 80220 <sup>4</sup>    | 42,308.2              | 42,308.2  | -         | 100.0   |
| 80802 <sup>5</sup>    | 2,750.0               | 2,750.0   | -         | 100.0   |
| 70205 <sup>6</sup>    | 1,177,739.5           | 980,561.9 | 197,177.6 | 83.3    |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн орлогоос 19,662.4 мянган төгрөгийн орлого хүлээн авч, 19,662.4 мянган төгрөгийг цалин, шимтгэл, бараа үйлчилгээний зардалд зориулалтын дагуу зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" заасны дагуу Дундговь аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

<sup>1</sup> Үндсэн үйл ажиллагааны зардал

<sup>2</sup> Мэдээлэл сурталчилгааны зардал

<sup>3</sup> Холбооны суваг ашиглалтын зардал

<sup>4</sup> Ажил олгогчоос олгох тэтгэмж

<sup>5</sup> Татвар хураалт, орлого бүрдүүлэлтийн зардал

Аудитыг Саруул баян уул -Аудит ХХК-ын аудитор Д.Оюунбат гүйцэтгэж, чанарын хяналтыг анхан шатанд ахлах аудитор Д.Ихбаяр, аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 08/36 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 696,151.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,961.5 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд жилийн эцсийн аудитын явцад дахин хянаж үзээд гүйцэтгэлийн үе шатанд нийт зардлын 1,294,856.3 мянган төгрөгөөс тооцоход 12,948.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг дахин тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийн 83.5 хувийг зарцуулж, 197,177.5 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ. Хэмнэгдсэн зардлын ихэнх хувь нь цалин, НДШ-ийн зардал байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төлөвлөсөн 29 горим сорилыг гүйцэтгэхэд тус хуулийг зөрчсөн асуудал аудитын явцад илрээгүй болно. Аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааг авч санхүүгийн аудитын системд оруулсан.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Татварын хэлтэс нь 2023 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулбал зохих 25 мэдээллээс 2,500.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй, 1 мэдээлэл хоцроож, хуулийн хэрэгжилт 98.4 хувьтай байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж үзсэн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дундговь аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийж гүйцэтгэсэн.

Завсрын аудитаар нийт 5,441.8 мянган төгрөгийн алдаа илрүүлж, асуудлын бүртгэлийг хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар биелэлтийг хянаж үзэхэд алдааг залруулсан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар даатгуулагчаас төлөх 1,001.2 мянган төгрөгийг НДШ-ийн зардлаас зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж өгснийг залруулж дахин давтан гаргахгүй байх талаар хариу ирүүлсэн байна.

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                | Биелэлт  |                |              |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|--------------|
|                 | Тоо                    | Дүн            | Тоо      | Дүн            | Хувь         |
| Албан шаардлага | 1                      | 1,001.2        | 1        | 1,001.2        | 100.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>1</b>               | <b>1,001.2</b> | <b>1</b> | <b>1,001.2</b> | <b>100.0</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн чанар, ашиглалтыг дараагийн аудитаар газар дээр нь үзэж горим, сорил хэрэгжүүлнэ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,483.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 100 хувь залруулсан.

#### Залруулсан алдаа

1. Үр дүнгийн тайланд цалин, НДШ-ийн зардлыг 3,577.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
2. ХХОАТ-ын өглөг 82.8 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй.
3. НДШ-ийн авлага 1,988.6 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй
4. Ээлжийн амралтыг илүү тооцож олгосон 3,324.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй.
5. Томилолтоор ажилласан албан хаагчид хоолны хөнгөлөлт 511.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т /үнэн, зөв байх/, 20 дугаар зүйлийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/заасныг, мөн үнэн зөв, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Мянган төгрөгөөр

| Алдааны товч утга  | Нийт алдаа |                | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                | Буруу тусган илэрхийлсэн |                | Үүнээс   |                |          |                | Зөвлөмж  |          |          |          |
|--|------------|----------------|-----------------------------------|----------------|--------------------------|----------------|----------|----------------|----------|----------------|----------|----------|----------|----------|
|  | Тоо        | Дүн            | Тоо                               | Дүн            | Тоо                      | Дүн            | Тоо      | Дүн            | Тоо      | Дүн            | Тоо      | Дүн      |          |          |
| Үр дүнгийн тайлан цалин, НДШ-ийн зардлыг зөрүүтэй тайлагнасан                  | 1          | 3,577.0        |                                   |                | 1                        | 3,577.0        |          |                | 1        | 3,577.0        |          |          |          |          |
| ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй.                        | 1          | 82.8           | 1                                 | 82.8           |                          |                |          |                | 1        | 82.8           |          |          |          |          |
| НДШ-ийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.                                  | 1          | 1,988.6        | 1                                 | 1,988.6        |                          |                |          |                | 1        | 1,988.6        |          |          |          |          |
| Ээлжийн амралтыг илүү тооцож олгосныг санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй | 1          | 3,324.5        | 1                                 | 3,324.5        |                          |                |          |                | 1        | 3,324.5        |          |          |          |          |
| Томилолтоор ажилласан албан хаагчид хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон.  | 1          | 511.0          |                                   |                |                          |                | 1        | 511.0          | 1        | 511.0          |          |          |          |          |
| <b>Дүн</b>   | <b>5</b>   | <b>9,483.9</b> | <b>3</b>                          | <b>5,395.9</b> | <b>2</b>                 | <b>4,088.0</b> | <b>5</b> | <b>9,483.9</b> | <b>5</b> | <b>9,483.9</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛГЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дундговь аймаг Татварын хэлтэс

Аудитын код:

Аудитын нэр:

Тайланг хугацаа:

ДУА-2024/35/НА-СТА-ТШЗ

Санхүүгийн тайлангийн аудит

2023.01.01-2023.12.31

Байгууллагын РД:9034218

| №   | Ажил гүйцэтгэний анг, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн          | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалтгалагч байгууллагын шалтгаал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар                               | Гаргасан шийдэл | Шалтгалагч байгууллагын холбогдох хүний |                            |
|---|--|--|---------------------|---------------------------------------|---|--|-----------------|---|----------------------------|
|   |  |  |                     |                                       |   |  |                 | Албан тушаал                            | Овог нэр                   |
| A   | 1  | 3  | 4.00                | 5                                     | 6   | 7  | 8               | 9                                       | 10                         |
| <b>1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны бүртгэл</b>  |  |  |                     |                                       |   |  |                 |   |                            |
| 1.1   | Үр дүнгийн тайлан                                | Үр дүнгийн тайлан цалин, НДШ-ийн зардлыг зөрүүтэй тайлагнасан                    | 3,577,016.63        | Залуулах                              | Зөвшөөрсөн                                |  | Залуулах        | Дарга, нягтлан бодогч                   | М.Туяацэцэг, Н.Долгорсүрэн |
| 1.2   | Өглөг  | ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн байдлын тайланда тусгаагүй.                         | 82,825.00           | Залуулах                              | Зөвшөөрсөн                                | 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд залруулсан                  | Залуулах        | Дарга, нягтлан бодогч                   | М.Туяацэцэг, Н.Долгорсүрэн |
| 1.3   | Авлага   | НДШ-ийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.                                    | 1,988,599.10        | Залуулах                              | Зөвшөөрсөн                                |  | Залуулах        | Дарга, нягтлан бодогч                   | М.Туяацэцэг, Н.Долгорсүрэн |
| 1.4   | Зардлын данс                                     | Эзлэгийн амралтыг илүү тоонож олгосныг санхүүгийн тайланд авлагаар тайлагнашгүй. | 3,324,493.00        | Залуулах                              | Зөвшөөрсөн                                | 2023 оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэх                             | Залуулах        | Дарга, нягтлан бодогч                   | М.Туяацэцэг, Н.Долгорсүрэн |
| 1.5   | Зардлын данс                                     | Томилгоотоор ажигласан албан хаагчид хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон.   | 511,000.00          | Залуулах                              | Зөвшөөрсөн                                | Илүү олгосон томилотын зардлыг 2023 оны 10 дугаар сарын цалинд суутгасан | Залуулах        | Дарга, нягтлан бодогч                   | М.Туяацэцэг, Н.Долгорсүрэн |
|   |  |  | <b>9,483,933.73</b> |                                       |   |  |                 |   |                            |
| <b>2. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл</b> |  |  |                     |                                       |   |  |                 |   |                            |
| <b>Зөрчлийн дүн</b>   |  |  |                     |                                       |   |  |                 |   |                            |
| <b>3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл</b>                       |  |  |                     |                                       |   |  |                 |   |                            |
| 3.1   |  |  | -                   |                                       |   |  |                 |   |                            |
| <b>Дүн</b>  |  |  |                     |                                       |   |  |                 |   |                            |
|   |  |  | <b>9,483,933.73</b> |                                       |   |  |                 |   |                            |

Бэлтгэсэн: Аудитор

Ханасан: Аудитын менежер

Ханасан: Дарга, Тэргүүлэх аудитор

/Д.Оюунбат/ Огноо: 2024.01.29

/Х.Наранцрал/ Огноо: 2024.01.29

/Р.Мөнхотгох/ Огноо: 2024.01.29

Тангилж, зөвшөөрсөн

Дарга

Нягтлан бодогч



/М.Туяацэцэг/ Огноо: 2024.01.29

/Н.Долгорсүрэн/ Огноо: 2024.01.29